

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

№01

Засгийн газрын 8 дугаар байр
Олимпийн гудамж – 2
Сүхбаатар дүүрэг 14120
Монгол Улс
Утас: 264269

Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт
тавигдах дэлгэрэнгүй шаардлага батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.13, 25.14 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам"-ын 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт тавигдах дэлгэрэнгүй шаардлага"-ыг хавсралтаар баталсугай.
2. Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт тавигдах дэлгэрэнгүй шаардлагыг сургалт эрхлэх байгууллага, холбогдох Мэргэжлийн салбар зөвлөлд танилцуулж мөрдүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д даалгасугай.
3. Энэхүү дэлгэрэнгүй шаардлага, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/121 дүгээр тушаалын наймдугаар хавсралтаар баталсан жагсаалтын дагуу үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн боловсруулж, 2019 оны 7 дугаар сард багтаан Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэхийг төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллагын дарга/захирал нарт, сургалтын хөтөлбөрийг Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх үйл ажиллагааг 2019 оны 8 дугаар сард багтаан зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Б.БЯМБАДОРЖ

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн
01 дугаар тогтоолын хавсралт

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх
сургалтын хөтөлбөр тавигдах дэлгэрэнгүй шаардлага

Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллага нь эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтыг тусгайлан боловсруулсан “ҮР ДҮНД СУУРИЛСАН ХӨТӨЛБӨР”-ийн дагуу зохион байгуулна.

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх) нь сургалтын зорилгод нийцсэн агуулга бүхий суралцахад үзүүлэх дэмжлэгийг төлөвлөсөн баримт бичиг байна.

Хөтөлбөр нь төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагын хүчин чадал, мэргэшлийн чиглэлээс үл хамааран хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үр дүнг хянах, үнэлхэхэд баримтлах үзэл баримтлал, зарчим, хүрэх үр дүнг илэрхийлсэн дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

1. Хөтөлбөрийн үндэслэл
2. Хөтөлбөрийн зорилго
3. Алсын хараа
4. Сургалтын зорилт
5. Сургалтын арга зүй
6. Сургалтын агуулга
7. Сургалтын үнэлгээ, эргэн зөвлөгөө
8. Хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, хяналт

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл

Хөтөлбөр боловсруулах болсон шалтгаан, тухайн үндсэн/терөлжсөн мэргэшлийн хэрэгцээ шаардлага (эрүүл мэндийн үзүүлэлт, хүний нөөцийн эрэлт хэрэгцээ), шинэчлэх, шинээр боловсруулах үндэслэл (шинэ техник технологи, оношилгоо, эмчилгээ, сувилгааны стандарт, заавар, удирдамж гэх мэт)-ийг тодорхойлж, тухайн чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх тогтолцооны үзэл баримтлалыг бичнэ.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Суралцагчийн хүрэх гэж эрмэлзэж буй үр дүнг тодорхойлсон, цогц чадамжийг тусгасан ерөнхий томьёолол байна. Сургалтын зорилго нь “Ямар мэдлэг, ур чадвар, хандлагатай мэргэжилтэн бэлтгэх вэ?” “Яагаад энэ мэргэшлийг сонгон судлах шаардлагатай вэ” гэсэн асуултад хариулахад чиглэнэ.

Гурав. Алсын хараа

Тухайн мэргэшлээр суралцаж төгсөх эмнэлгийн мэргэжилтний дүр зураг, нийгмийн өмнө хүлээх үүргийг тодорхойлно.

Дөрөв. Сургалтын зорилт

Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх зорилтыг тодорхойлохдоо мэргэжлийн мэдлэг (*Knowledge*), ур чадвар (*Skills*), эмчийн ёс зүй, хандлага (*Attitude*)-ыг заавал тусгана. Зорилт нь хэмжигдэхүйц, үнэлэх боломжтой байна.

Тав. Сургалтын арга зүй

Сургалтын зорилтод хүрэхийн тулд суралцагч төвтэй, тэдний оролцоог дэмжсэн, эмнэл зүйд суурилсан идэвхтэй арга хэлбэрийг хослуулсан байна. Ашиглаж болохуйц нөөцийг тодорхойлж амжилттай хэрэгжүүлэх аргыг сонгосон байна. Үүнд:

- ажлын байрны сургалт (*On-the-Job Training*)
- танхимын сургалт (*Off-the Job Training*)
- бие даан суралцах (*Self-Development Training*)

Сургалтын чиглэл, хугацаа, сургалт эрхлэх байгууллага, сүлжээ эмнэлэг, тасаг нэгж, анги танхимыг тодорхой тусгана.

Сургалтын ерөнхий төлөвлөгөөг гаргана.

Загвар 1.

Ажлын байрны сургалт (*On-the-Job Training*)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Амбулаторийн үзлэг хийх	1	3 цаг 7 хоногт 2 удаа	Амбулатори	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Хяналтын тойрон үзлэг хийх	3 - 5	1 цаг Өдөр бүр	Тасаг	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Сургалтын тойрон үзлэг хийх	20 хүртэл	1 цаг 7 хоногт 1 удаа	Сургалтын өрөө, танхим	Слайд	Эмнэл зүйн сургагч багш
Мэс засалд оролцох	1	Тохиолдол байгаа үед	Мэс заслын өрөө	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Жирэмсэн, төрсний дараах хяналт хийх	1	Хяналтад байгаа жирэмсэн эх, терсэн эх	Амбулатори, гэрээр	Жирэмсэн эх, терсэн эх	Эмнэл зүйн сургагч багш
Төрөлт удирдахад оролцох	1	Тохиолдол байгаа үед	Төрөх өрөө	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Гардан үйлдэл хийх	1 - 2	Тохиолдол байгаа үед	Яаралтай тусламжийн өрөө	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч

Аргачлал (амбулаторийн үзлэг, хяналтын тойрон үзлэг, сургалтын тойрон үзлэг, гардан үйлдэл гэх мэт) тус бүрээр сургалтыг хэрхэн үр дүнтэй зохион байгуулахыг дэлгэрэнгүй тодорхойлж бичнэ.

Загвар 2.

Танхимын сургалт (*Off-the Job Training*)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Бие даалт	1	Тохиромжтой, чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернет	Өөрөө, хамтран суралцагч эмч
Лекц	20 хүртэл	7 хоногт 2-3 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд	Эмнэл зүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Журнал клуб	20 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд, эрдэм шинжилгээний өгүүлэл	Эмнэл зүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Симуляци (дуураймал орчин)	5 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Яаралтай тусламжийн өрөө	Хамтран суралцагч эмч, манекин	Эмнэл зүйн сургагч багш

Загвар 3.

Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
~ 8:00	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг
8:00-9:00	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг
9:00-12:00		Амбулаторийн үзлэг		Амбулаторийн үзлэг	
12:00-13:00	Лекц, семинар		Лекц, семинар	Симуляци (дуураймал орчин)	Журнал клуб
16:00-17:00	Сургалтын тойрон үзлэг				

Бие даан суралцах (*Self-Development Training*) агуулга, аргыг тодорхойлж, оношилгоо, эмчилгээний стандарт, заавар, удирдамж, цахим сургалт (*E-Learning*)-ын талаар тодорхой тусгана.

Зургаа. Сургалтын агуулга

Тухайн мэргэшлээр зайлшгүй эзэмших шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг тусгасан хөтөлбөрийн хамгийн гол хэсэг.

Сургалтын хугацаанд жилээс жилд мэдлэг, чадвар, хандлагад ахиц, дэвшил гаргахад анхаарна.

Сургалт эрхлэх байгууллагаас үл хамааран тухайн мэргэшлээр зайлшгүй эзэмшиж төгсөх ур чадвар, чадамжийг сургалтын агуулгад тусгана. Сургалт эрхлэх байгууллагын тусламж, үйлчилгээний онцлогоос хамаарч сургалтын агуулгад

нэмэлт оруулж болно. Сургалтын агуулга, түүнд оруулах нэмэлтийг холбогдох Мэргэжлийн салбар зөвлөл шалгаж батална.

Долоо. Сургалтын үнэлгээ, эргэн зөвлөгөө

Суралцагчийн үнэлгээ нь ажлын байранд суурилсан үнэлгээ байна. Үүнд: мэдлэг, харилцаа хандлага, ур чадварын үнэлгээ хамаарна.

Жишээлбэл: олон хувилбарт сорил, эмнэл зүйн бодлого, 360 хэмийн үнэлгээ (360-Degree Assessment), Эмнэл зүйн дасгал үнэлгээ/Mini-CEX (Mini-Clinical Evaluation Exercise), Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт /DOPS (Direct Observation of Procedural Skills), Портфолио үнэлгээ (Portfolio Assessment) гэх мэт.

Үнэлгээний шалгуурыг тодорхой гаргаж, дамжаа дэвшин суралцах болон төгсөлтийн шалгалтад орох шалгуурыг тусгана.

Сургалтын зорилттой уялдуулан ур чадварыг бататгах, ахиулах үнэлгээний түвшин гаргаж болно. Жишээлбэл - эмнэл зүйн удирдагч багшийн гүйцэтгэх тусламж, үйлчилгээнд туслах, - багийн гишүүнээр ажиллах, - бие даан гардан үйлдэх гэх мэт.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, хяналт

Сургалтын алба, сургалтын хяналтын зөвлөлөөс хариуцан хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үнэлэх, нэмэлт, өөрчлөлт хийх, шинэчлэх үйл ажиллагааг тодорхойлно.

Сургалтын жилийн эцэст суралцагчийн зүгээс эмнэл зүйн сургагч багш болон хөтөлбөрт хэрхэн үнэлгээ өгөх, хөтөлбөрт тодорхой бус, ойлгомжгүй зүйл байвал хаана хандаж, шийдвэрлүүлэх талаар тусгана.

Загвар 4.

- Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт (*Faculty Development*), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрийн төгсгөлд суралцагч болон эмнэл зүйн сургагч багш, хөтөлбөр хариуцсан мэргэжилтнээс асуумж судалгаа авч дүгнэн, үр дүнг Эрүүл мэндийн хөгжлийн төвд тайлагнаж, шаардлагатай тохиолдолд хөтөлбөрийг сайжруулах арга хэмжээг судлан жил тутамд нэмэлт, өөрчлөлт оруулж болно /бага хэмжээний өөрчлөлт/
- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд Сургалтын хяналтын зөвлөлд оруулж хэлэлцүүлж, энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.
- Хөтөлбөрийн агуулгыг 5 жил тутамд шинэчилнэ.

Нэмэлтээр: Суралцагчийн сургалтын гарын авлага, эмнэл зүйн сургагч багшийн гарын авлага, суралцагчийн дэвтэр, эмнэл зүйн сургагч багшийн журналыг хэрхэн боловсруулах, ашиглах талаар хөтөлбөрт тусгаж болно.